



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 4 сарын 04 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Үнэт цаасны компанийн харилцагчдыг шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-ын 3.4, 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 48, 168 дугаар тогтоолуудаар үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон “Ай трейд ҮЦК” ХХК, “Эм Даблью Ти Эс ҮЦК” ХХК, “Финанс линк групп ҮЦК” ХХК, “Говийн ноён нуруу ҮЦК” ХХК, “Превалент ҮЦК” ХХК, “Би Би Эс Эс ҮЦК” ХХК-ийн нийт 30 155 харилцагчийг “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д, “Зюс капитал ҮЦК” ХХК-ийн нийт 289 харилцагчийг “Би Ди Сек ҮЦК” ХК-д, “Бага хээр ҮЦК” ХХК-ийн 711 харилцагчийг “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК-д тус тус шилжүүлэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч /Б.Долгурсүрэн/, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Бумбат Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/, “Би Ди Сек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/, “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК /Н.Оюунтунгалаг/-д тус тус үүрэг болгосугай:

1/ Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон нэр бүхий 8 компанийн харилцагчдын данс нээсэн болон үнэт цаасны арилжааны хэлцлийн анхан шатны баримтыг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүлээлцэх;

2/ Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон нэр бүхий 8 компанийн харилцагчдын үнэт цаасны арилжаанд оролцох боломжийг хангах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-д заасан үүргээ чанд биелүүлж ажиллах.

3. Шилжүүлэн авсан харилцагчдадаа шаардлагатай мэдээллийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан хүргэж ажиллахыг “Бумбат Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/, “Би Ди Сек

ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/, “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК /Н.Оюунтунгалаг/-д тус тус даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц /-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН